

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Татварын ерөнхий газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/10/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2023 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: <a href="mailto:chantsaldulamp@audit.gov.mn">chantsaldulamp@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Э.Энхбаатар Утас: 51-261740 Цахим хаяг: <a href="mailto:enkhbaatare@audit.gov.mn">enkhbaatare@audit.gov.mn</a> Аудитор: Т.Баасанцэнд Утас: 51-261740 Цахим хаяг: <a href="mailto:baasantsendt@audit.gov.mn">baasantsendt@audit.gov.mn</a> Аудитор: О.Наранбат Утас: 51-261740 Цахим хаяг: <a href="mailto:naranbato@audit.gov.mn">naranbato@audit.gov.mn</a>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/825  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Татварын ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Татварын ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь аудитын дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж байгаа "Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн барилгыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр 9,480.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр анхны гэрээг байгуулсан, "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-аар магадлуулан ирүүлсэн гүйцэтгэгчийн төсөвт өртөг 13,450.7 сая төгрөг, Монгол Улсын Их Хурлын 2021 оны "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуультай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 88 дугаар тогтоолын дагуу холбогдох газруудаас хянаж магадлан 2023 оны төсөвт 1,999.2 сая төгрөгийн үнийн өсөлтийн нэмэгдлийг тусган баталж, барилгын нийт төсөвт өртөг 15,449.9 сая төгрөг болж нэмэгдсэн байна.

### Аудитын гол асуудал

Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулиар Татварын ерөнхий газар нь 7,710.3 тэрбум төгрөгийн татварын орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 9,516.4 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлж, төлөвлөгөөний гүйцэтгэл 123.42 хувьтай байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Татварын ерөнхий газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан “Цахим татварын алба” зорилтын хүрээнд 16, “Хууль тогтоомж чиг үүрэг” зорилтын хүрээнд 38, нийт 54 арга хэмжээг 98.4 хувийн биелэлттэй гүйцэтгэсэн байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийн мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,708,642.5	4,371,802.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	422,477.2	1,784,193.6
33	АВЛАГА	175,035.9	633,572.7
34	УРЬДЧИЛГАА	283.3	2,483.3
35	БАРАА МАТЕРИАЛ	2,110,846.1	1,951,552.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	56,310,805.2	53,071,623.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	56,310,805.2	53,071,623.9
39200	Биет хөрөнгө	46,268,847.4	47,389,361.2
39300	Биет бус хөрөнгө	10,041,957.8	5,682,262.7
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>59,019,447.8</b>	<b>57,443,426.4</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	134,528.9	1,658,644.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	134,528.9	1,658,644.9
41300	Өглөг	133,438.6	1,375,622.2
41400	Урьдчилж орсон орлого	1,090.4	283,022.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	58,884,918.8	55,784,781.5
51	Засгийн газрын хувь оролцоо	58,884,918.8	55,784,781.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	20,015,564.2	18,798,259.5
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.0	1,217,304.8
51200	Хуримтлагдсан үр дүн	34,712,770.9	31,601,339.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,156,583.7	4,167,877.5
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>59,019,447.8</b>	<b>57,443,426.4</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	54,831,321.0	87,089,117.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,686,288.1	8,459,968.9
120	Нийтлэг татварын бус орлого	9,670,188.1	8,459,968.9
121	Хөрөнгийн орлого	16,100.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	45,145,032.8	78,629,148.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	61,179,240.5	89,835,315.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,179,240.5	88,687,411.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,318,944.0	79,332,644.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,417,296.5	48,579,109.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,539,305.8	6,184,404.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,626,222.3	2,088,505.2
2104	Хангамж, бараа материалын зардал	1,593,801.3	1,659,350.2
2105	Нормативт зардал	55,447.2	45,614.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	282,894.8	588,297.9
2107	Томилолт, зочны зардал	187,172.4	244,863.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,142,922.1	8,369,275.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,473,881.7	11,573,223.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,860,296.5	9,354,766.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	1,147,903.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(6,347,919.5)	(2,746,197.2)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	186,805.7	351,289.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(6,534,725.2)	(3,097,487.0)

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>65,419,753.8</b>	<b>0.0</b>	<b>65,419,753.8</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(109.7)	0.0	(109.7)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	65,419,644.0	0.0	65,419,644.0
9	Тайлант үеийн үр дүн	(6,534,725.2)	0.0	(6,534,725.2)
10	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>58,884,918.8</b>	<b>0.0</b>	<b>58,884,918.8</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(2,650.3)	0.0	(2,650.3)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	58,882,268.5	0.0	58,882,268.5
19	Тайлант үеийн үр дүн	(3,097,487.0)	0.0	(3,097,487.0)
20	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>55,784,781.5</b>	<b>0.0</b>	<b>55,784,781.5</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>363,062,192.7</b>	<b>483,951,061.8</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,580,645.2	6,541,222.9
120	Нийтлэг татварын бус орлого	4,564,545.2	6,541,222.9
121	Хөрөнгийн орлого	16,100.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	358,481,547.5	477,409,839.0
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>358,171,557.9</b>	<b>477,754,334.9</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	358,171,557.9	477,754,334.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,147,326.9	69,201,768.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,494,900.5	48,742,230.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,503,961.6	6,111,986.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,634,363.5	2,088,883.9
2104	Хангамж, бараа материалын зардал	1,141,768.9	1,256,335.6
2105	Нормативт зардал	737.2	1,294.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	273,621.0	619,254.6
2107	Томилолт, зочны зардал	104,631.0	193,633.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,237,945.0	9,293,712.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	755,398.2	894,436.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	315,024,231.0	408,552,566.3
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>4,890,634.8</b>	<b>6,196,727.0</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>4,950,154.9</b>	<b>4,835,010.6</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,950,154.9	4,835,010.6
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(4,950,154.9)</b>	<b>(4,835,010.6)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>(59,520.1)</b>	<b>1,361,716.4</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	481,997.3	422,477.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	422,477.2	1,784,193.6

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>78,297,310,100.00</b>	<b>72,517,497,657.10</b>	<b>5,779,812,442.90</b>	<b>92.6</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	75,608,110,100.00	69,828,297,657.10	5,779,812,442.90	92.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,011,811,800.00	67,460,894,807.10	5,550,916,992.90	92.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,905,696,400.00	47,728,803,279.51	4,176,893,120.49	92.0
Үндсэн цалин	23,483,639,800.00	23,079,264,359.31	404,375,440.69	98.3
Нэмэгдэл	11,070,608,600.00	9,835,256,450.71	1,235,352,149.29	88.8
Унаа хоолны хөнгөлөлт	3,566,292,600.00	2,944,785,015.97	621,507,584.03	82.6
Урамшуулал	13,785,155,400.00	11,868,626,944.52	1,916,528,455.48	86.1
Гэрээт ажлын хөлс	0.00	870,509.00	(870,509.00)	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,538,213,200.00	5,994,427,840.21	543,785,359.79	91.7
Тэтгэврийн даатгал	4,445,984,400.00	4,101,590,195.21	344,394,204.79	92.3
Тэтгэмжийн даатгал	523,057,100.00	486,054,547.71	37,002,552.29	92.9
ҮОМШӨ-ний даатгал	418,445,800.00	382,283,109.87	36,162,690.13	91.4
Ажилгүйдлийн даатгал	104,611,900.00	95,998,836.16	8,613,063.84	91.8
Эрүүл мэндийн даатгал	1,046,114,000.00	928,501,151.26	117,612,848.74	88.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,198,151,700.00	2,088,883,939.60	109,267,760.40	95.0
Гэрэл, цахилгаан	327,968,800.00	269,569,944.22	58,398,855.78	82.2
Түлш, халаалт	787,904,500.00	753,867,764.30	34,036,735.70	95.7
Цэвэр, бохир ус	104,980,700.00	89,647,283.08	15,333,416.92	85.4
Байрны түрээс	977,297,700.00	975,798,948.00	1,498,752.00	99.8
Хангамж, бараа материалын зардал	847,923,800.00	774,515,781.83	73,408,018.17	91.3
Бичиг хэрэг	186,828,000.00	177,686,994.00	9,141,006.00	95.1
Тээвэр, шатахуун	149,239,500.00	132,736,229.00	16,503,271.00	88.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	233,017,000.00	200,019,209.83	32,997,790.17	85.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,925,800.00	11,987,360.00	(61,560.00)	100.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	266,913,500.00	252,085,989.00	14,827,511.00	94.4
Нормативт зардал	12,982,100.00	1,294,670.00	11,687,430.00	10.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,982,100.00	1,294,670.00	11,687,430.00	10.0
Эд хогшил, урсгал засварын зардал	651,632,900.00	556,486,199.33	95,146,700.67	85.4
Багаж, техник, хэрэгсэл	103,565,800.00	83,150,000.00	20,415,800.00	80.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	25,905,900.00	5,752,500.00	20,153,400.00	22.2
Урсгал засвар	522,161,200.00	467,583,699.33	54,577,500.67	89.5
Томилолт, зочны зардал	234,768,700.00	174,258,227.80	60,510,472.20	74.2
Гадаад албан томилолт	31,062,000.00	31,034,821.80	27,178.20	99.9
Дотоод албан томилолт	203,706,700.00	143,223,406.00	60,483,294.00	70.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,166,297,300.00	9,766,104,458.82	400,192,841.18	96.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,644,133,000.00	3,599,178,921.16	44,954,078.84	98.8
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,441,600.00	7,441,600.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	14,514,100.00	13,615,605.00	898,495.00	93.8
Тээврийн хэрэгслийн татвар	5,136,600.00	4,796,648.00	339,952.00	93.4
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,256,000.00	1,152,000.00	104,000.00	91.7
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,102,877,400.00	2,099,618,618.98	3,258,781.02	99.8
Газрын төлбөр	7,704,800.00	6,312,830.00	1,391,970.00	81.9

Татварын ерөнхий газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,383,233,800.00	4,033,988,235.68	349,245,564.32	92.0
Бараа үйлчилгээний бусад зардал	456,145,700.00	376,120,410.00	80,025,290.00	82.5
Бараа үйлчилгээний бусад зардал	92,090,300.00	58,360,470.00	33,729,830.00	63.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	364,055,400.00	317,759,940.00	46,295,460.00	87.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,596,298,300.00	2,367,402,850.00	228,895,450.00	91.2
Бусад урсгал шилжүүлэг	2,596,298,300.00	2,367,402,850.00	228,895,450.00	91.2
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	633,984,200.00	608,693,200.00	25,291,000.00	96.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,751,981,900.00	1,552,426,799.00	199,555,101.00	88.6
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	210,332,200.00	206,282,851.00	4,049,349.00	98.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,689,200,000.00	2,689,200,000.00	0.00	100.0
Барилга байгууламж	2,689,200,000.00	2,689,200,000.00	0.00	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>78,297,310,100.00</b>	<b>72,517,447,657.10</b>	<b>5,779,862,442.90</b>	<b>92.6</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>75,287,310,100.00</b>	<b>68,924,275,468.06</b>	<b>6,363,034,631.94</b>	<b>91.5</b>
Улсын төсвөөс санхүүжих	75,287,310,100.00	68,924,275,468.06	6,363,034,631.94	91.5
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>3,010,000,000.00</b>	<b>3,593,172,189.04</b>	<b>(583,172,189.04)</b>	<b>119.4</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,890,000,000.00	3,593,130,189.04	(703,130,189.04)	124.3
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,000,000.00	42,000.00	119,958,000.00	0.0
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>1,834</b>	<b>1,696</b>	<b>138</b>	<b>92.5</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>33</b>	<b>33</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>1,834</b>	<b>1,696</b>	<b>138</b>	<b>92.5</b>
Удирдах ажилтан	55	55	0.0	100.0
Гүйцэтгэх ажилтан	1,397	1,517	(120)	108.6
Үйлчлэх ажилтан	382	124	258	32.5
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>1,834</b>	<b>1,696</b>	<b>138</b>	<b>92.5</b>
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,687	1,572	115	93.2
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	147	124	23	84.4

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>3,761,275,227.36</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>3,724,629,227.36</b>
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,828,084,936.12
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,012,767,496.55
Үндсэн цалин		239,730,675.37
Нэмэгдэл		271,215,793.22
Урамшуулал		501,821,027.96
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		117,558,328.42
Тэтгэврийн даатгал		96,925,485.89
Тэтгэмжийн даатгал		5,188,357.11
ҮОМШӨ-ний даатгал		4,244,521.44
Ажилгүйдлийн даатгал		1,028,412.03
Эрүүл мэндийн даатгал		10,171,551.95
Хангамж, бараа материалын зардал		496,918,026.09
Бичиг хэрэг		205,390,319.00
Тээвэр, шатахуун		152,087,386.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		59,526,388.09
Ном, хэвлэл		21,000,000.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		60,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		58,853,933.00
Эд хогшил, урсгал засварын зардал		114,335,969.00
Багаж, техник, хэрэгсэл		24,039,500.00
Урсгал засвар		90,296,469.00
Томилолт, зочны зардал		19,375,200.00
Дотоод албан томилолт		19,375,200.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		607,465,979.06
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		596,508,166.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		10,957,813.06
Бараа үйлчилгээний бусад зардал		459,663,937.00
Бараа үйлчилгээний бусад зардал		170,515,780.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		289,148,157.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>896,544,291.24</b>
Бусад урсгал шилжүүлэг		548,920,625.05
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		54,500,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		494,420,625.05
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		347,623,666.19
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		178,006,292.19
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		147,207,324.16
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		22,410,049.84
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>36,646,000.00</b>
Дотоод эх үүсвэрээр		36,646,000.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>3,761,275,227.36</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>3,761,275,227.36</b>
ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,427,207,365.52
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		150,482,402.84
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,183,585,459.00
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		<b>0.00</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Татварын ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд 33 байгууллагын тайланг нэгтгэснээс 27 шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд Өөрчлөлтгүй дүгнэлт өгч, 6 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

#### 3.1 Төсвийн төвлөрүүлэн захирагч

##### 3.1.1 Албан шаардлага

Монголын үнэт цаас ХХК-аас 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр ОАТ-ын тэмдэг худалдан авахаар 397.8 сая төгрөгийг шилжүүлж, 311.9 сая төгрөгийг байгууллагаас авах авлагаар бүртгэж тайлагнасан байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, 7 дугаар зүйлийн 7.7 Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Онгой албан татварын тэмдэг худалдан авалтын хэмжээг оновчтой тодорхойлоогүй, авлага үүсгэсэн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

##### 3.1.2 Зөвлөмж

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Татварын ерөнхий газар нь тайлант онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болон шуудан холбоо интернэтийн төлбөрийн 169.7 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө" гэсэн заалттай нийцэхгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлж, зардлыг шууд зардлаар бүртгэсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх.

2. Дотоод хяналттай холбоотой

###### Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,248.8 сая төгрөгийн 45 алдаа, 252.9 сая төгрөгийн 55 зөрчил, нийцлийн асуудалтай холбоотой 1,102.5 сая төгрөгийн 14 зөрчил илэрсэн байна. Харьяа байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчил нь өмнөх оны аудитаар илэрсэн 2,623.3 сая төгрөгийн алдаа, 550.0 сая төгрөгийн зөрчлөөс дунджаар 49.4 хувиар буурсан байна.

###### Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, харьяа байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулж, давтан гаргахгүй байх.

Аудитаар нийт 233.2 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 233.2 сая төгрөгийн 2 алдааг бүрэн залрууллаа.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 1,481.9 сая төгрөгийн 47 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Татварын ерөнхий газар	1	42,150.9			1	42,150.9	1	42,150.9				
2	Том татвар төлөгчийн газар	1	190,984.3			1	190,984.3	1	190,984.3				
3	Нийслэлийн Татварын газар	5	153,558.8	5	153,558.8			5	153,558.8				
4	Баянгол дүүргийн ТХ	2	24,472.4			2	24,472.4	2	24,472.4				
5	Баянзүрх дүүргийн ТХ	2	324,360.0			2	324,360.0	2	324,360.0				
6	Сүхбаатар дүүргийн ТХ	3	46,774.1	1	8,924.6	2	37,849.5	3	46,774.1				
7	Хан-Уул дүүргийн ТХ	1	69,390.6			1	69,390.6	1	69,390.6				
8	Багануур дүүргийн ТХ	3	109,190.4	2	1,854.0	1	107,336.4	3	109,190.4				
9	Багахангай дүүргийн ТХ	1	6,557.2			1	6,557.2	1	6,557.2				
10	Налайх дүүргийн ТХ	5	67,227.0			5	67,227.0	5	67,227.0				
11	Баян-Өлгий аймгийн ТХ	3	39,194.0			3	39,194.0	3	39,194.0				
12	Говь-Алтай аймгийн ТХ	2	7,581.6			2	7,581.6	2	7,581.6				
13	Говьсүмбэр аймгийн ТХ	1	98,365.4			1	98,365.4	1	98,365.4				
14	Дорнод аймгийн ТХ	2	2,620.0			2	2,620.0	2	2,620.0				
15	Дундговь аймгийн ТХ	5	9,483.9	3	5,395.9	2	4,088.0	5	9,483.9				
16	Орхон аймгийн ТХ	5	13,972.2	1	263.8	4	13,708.4	5	13,972.2				
17	Өмнөговь аймгийн ТХ	2	259,487.2			2	259,487.2	2	259,487.2				
18	Ховд аймгийн ТХ	2	1,548.1	2	1,548.1			2	1,548.1				
19	Хэнтий аймгийн ТХ	1	15,014.9			1	15,014.9	1	15,014.9				
	<b>Нийт дүн</b>	<b>47</b>	<b>1,481,933.0</b>	<b>14</b>	<b>171,545.2</b>	<b>33</b>	<b>1,310,387.8</b>	<b>47</b>	<b>1,481,933.0</b>				

Аудитаар нийт 734.5 сая төгрөгийн 58 зөрчил илэрснээс, 5.4 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 381.7 сая төгрөгийн 14 албан шаардлага хүргүүлж, 347.4 сая төгрөгийн 40 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Үндэсний татварын ерөнхий газар	3	481,597.9			1	311,900.0	2	169,697.9				
2	Нийслэлийн Татварын газар	5	15,262.8					5	15,262.8				
3	Баянгол дүүргийн ТХ	3	1,844.4					3	1,844.4				
4	Баянзүрх дүүргийн ТХ	1	19,000.0					1	19,000.0				
5	Сонгинохайрхан дүүргийн ТХ	6	41,841.2	1	4,000.0	1	25,855.0	4	11,986.2				
6	Чингэлтэй дүүргийн ТХ	2	7,363.0					2	7,363.0				
7	Сүхбаатар дүүргийн ТХ	4	13,439.6			1	5,929.6	3	7,510.0				
8	Хан-Уул дүүргийн ТХ	4	26,133.0			1	3,100.0	3	23,033.0				
9	Багануур дүүргийн ТХ	1	54.7					1	54.7				
10	Налайх дүүргийн ТХ	5	10,848.9	1	813.3			4	10,035.6				
11	Архангай аймгийн ТХ	3	4,013.1			3	4,013.1						
12	Баян-Өлгий аймгийн ТХ	1	28,632.0					1	28,632.0				
13	Булган аймгийн ТХ	1	7,327.8					1	7,327.8				
14	Говь-Алтай аймгийн ТХ	2	13,545.6			2	13,545.6						
15	Говьсүмбэр аймгийн ТХ	1	3,498.6			1	3,498.6						
16	Дорноговь аймгийн ТХ	1	-					1	-				
17	Орхон аймгийн ТХ	6	13,286.6	1	506.7	1	-	4	12,779.9				
18	Өмнөговь аймгийн ТХ	3	13,924.8	1	54.8	2	13,870.0						
19	Сүхбаатар аймгийн ТХ	2	-			1	-	1	-				
20	Сэлэнгэ аймгийн ТХ	1	840.0					1	840.0				
21	Төв аймгийн ТХ	1	32,076.6					1	32,076.6				
22	Хөвсгөл аймгийн ТХ	2	-					2	-				
	<b>Нийт дүн</b>	<b>58</b>	<b>734,530.6</b>	<b>4</b>	<b>5,374.8</b>	<b>14</b>	<b>381,711.9</b>	<b>40</b>	<b>347,443.9</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1,184.0 сая төгрөгийн 26 зөрчил илэрснээс 588.4 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 595.6 сая төгрөгийн 23 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>									
1	Үндэсний татварын ерөнхий газар	1	-					1	-
2	Том татвар төлөгчийн газар	1	-					1	-
3	Нийслэлийн Татварын газар	1	5,996.6			1	5,996.6		
4	Сонгинохайрхан дүүргийн ТХ	1	-					1	-
5	Чингэлтэй дүүргийн ТХ	1	246,762.0					1	246,762.0
6	Хан-Уул дүүргийн ТХ	1	38,577.2					1	38,577.2
7	Багануур дүүргийн ТХ	1	-					1	-
8	Налайх дүүргийн ТХ	1	582,375.5			1	582,375.5		
9	Баянхонгор аймгийн ТХ	1	77,424.0					1	77,424.0
10	Говь-Алтай аймгийн ТХ	1	-			1	-		
11	Дархан-Уул аймгийн ТХ	1	78,954.9					1	78,954.9
12	Дорноговь аймгийн ТХ	1	25,790.0					1	25,790.0
13	Орхон аймгийн ТХ	1	-					1	-
14	Өмнөговь аймгийн ТХ	1	43,300.0					1	43,300.0
15	Сүхбаатар аймгийн ТХ	1	-					1	-
16	Төв аймгийн ТХ	1	3,335.3					1	3,335.3
	<b>Дүн</b>	16	1,102,515.5	0	-	3	588,372.1	13	514,143.4
<b>Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>									
1	Баянзүрх дүүргийн ТХ	2	31,938.0					2	31,938.0
2	Сонгинохайрхан дүүргийн ТХ	1	4,806.7					1	4,806.7
3	Чингэлтэй дүүргийн ТХ	2	26,999.9					2	26,999.9
4	Налайх дүүргийн ТХ	1	-					1	-
5	Говьсүмбэр аймгийн ТХ	2	-					2	-
6	Дорноговь аймгийн ТХ	1	9,888.2					1	9,888.2
7	Дорнод аймгийн ТХ	1	7,869.8					1	7,869.8
	<b>Дүн</b>	10	81,502.6	0	-	0	-	10	81,502.6
	<b>Нийт</b>	26	1,184,018.1	0	-	3	588,372.1	23	595,646.0